

БАТЛАВ.  
НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН  
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.БАЯРСАЙХАН

**СХД-ийн 4, 5 дугаар хорооны далан дагасан авто замын засвар,  
шинэчлэлт. (Толгойтын замаас далан дагаад Баянхошууны зам)-ийн  
АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

<p><b>1.Ерөнхий зүйл</b></p>	<p>Объектын нэр: СХД-ийн 4, 5 дугаар хорооны далан дагасан авто замын засвар, шинэчлэлт. (Толгойтын замаас далан дагаад Баянхошууны зам)-ийн ажил.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Авто зам, замын байгууламжийн зураг төсөл</li> <li>- Төсөв / Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/141 дугаар тушаал болон Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/20 дугаар тушаалаар батлагдсан Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм дүрмийн дагуу тооцох/</li> </ul> <p>Гудамж замын ангилал: Гол гудамж зам</p>
<p><b>2.Барилгын талбайн үзүүлэлт</b></p>	<p>Авто замд өргөтгөл шинэчлэлтийн ажил хийгдэнэ.</p>
<p><b>3.Ажлын цар хүрээ</b></p>	<p><u>Зураг төсөл боловсруулах үе шат:</u></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Авто замын зураг төсөл боловсруулах даалгаварыг үндэслэн зураг төслийг боловсруулах</li> </ol> <p><u>Авто замын барилгын үе шатны ажил:</u></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Барилгын ажил эхлэх зөвшөөрлийг холбогдох газраас албан ёсоор авсан байна.</li> <li>2. Ажил гүйцэтгэх зураг төслийг батлуулсны дараа ажлын зураг, төлөвлөгөө, заавар, аргачлал, техникийн шаардлагын дагуу авто замын барилгын ажлыг хэрэгжүүлж эхэлнэ.</li> <li>3. Батлагдсан зураг төслийн дагуу засвар шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэх.</li> </ol>
<p><b>4.Ажлын хил хязгаар</b></p>	<p>Төсөл арга хэмжээнд хамаарах талбай СХД-ийн 4, 5 дугаар хорооны далан дагасан авто замын засвар, шинэчлэлт. (Толгойтын замаас далан дагаад Баянхошууны зам)-ийн ажил. /Авто замын зураг төсөл боловсруулах даалгавараас байршлын зургийг үзэх/</p>
<p><b>5.Барилгын ажлын зохион байгуулалт</b></p>	<ol style="list-style-type: none"> <li>1) Гүйцэтгэгч гэрээ байгуулсны дараа ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрмийн дагуу зөвшөөрөл авна.</li> <li>2) Захиалагч барилгын ажлын талбайг гүйцэтгэгчид хүлээлгэн өгөх ба өгснөөс хойш ашиглалтад оруулах хүртэл хугацаанд ажлын талбайг эзэмших эрхийг захиалагч бичгээр баталгаажуулна. Энэ хугацаанд гүйцэтгэгч нь аюулгүй байдлыг хангаж ажиллана.</li> <li>3) Засвар шинэчлэлтийн ажлыг зохион байгуулахдаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх арга хэмжээ авч, хөдөлмөр хамгаалал,</li> </ol>

	<p>аюулгүй байдал /түр зам, хаалт, тэмдэг тэмдэглэгээ г.м/-ын бүрэн хангаж ажиллана.</p> <p>4) Гүйцэтгэгч нь төслийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажил /байнгын болон түр ашиглах талбайг оролцуулан/-тай холбоотой дэвсгэр зургийг эрх бүхий байгууллагатай зөвшилцөж эцсийн байдлаар батлуулан захиалагчид хүлээлгэн өгнө.</p> <p>5) Тухайн ажлыг хариуцан ажиллах инженер, техникийн ажилчид нь уг ажлыг эхлэхээс ашиглалтад хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд энэ төслөөс өөр бусад төсөлд давхар ажиллахгүй болохыг анхаарч, хүн хүч, машин, механизмийн хуваарилалтын графикийг батлуулж ажиллана. Үйлдвэрийн сертификат, итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтээр баталгаажсан чанарын шаардлага хангасан материалыг хэрэглэнэ.</p> <p>6) Гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, ажил эхлэх дуусах хугацааг мэдээллийн самбарт үзүүлж олон нийтэд үзэгдэхүйц газар байршуулна. Ажлыг батлагдсан төлөвлөгөө, аргачлалын дагуу гүйцэтгэнэ. Ажил гүйцэтгэх төлөвлөгөөнд шаардагдах хүн хүчний графикийг хамтатган батлуулна. Ажлыг гүйцэтгэхдээ өөрийн гүйцэтгэж байгаа ажил, явганаар зорчиж байгаа ард иргэдэд бэрхшээл учруулахгүй байх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хаах нөхцөлд холбогдох байгууллагуудад урьдчилан мэдэгдэж, түр зам гаргаж байнгын арчилгаатай байлган оршин суугчдын ая тухтай зорчих байдлыг ханган ажиллаж, зохих зөвшөөрлийг авсан байх талаар анхаарч ажлын зохион байгуулалт, хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг нарийн баримтлан ажиллах шаардлагатай. НАЗХГ-ын даргын 2016 оны А/42 дугаар тушаалаар баталсан “Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлага”-ыг баримтлан гүйцэтгэнэ. Ингэхдээ итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтийг үндэслэн чанартай, шаардлага хангасан материалыг хэрэглэнэ.</p> <p>7) Гүйцэтгэгч 7 хоног тутамд хийгдсэн ажлын тайлбар болон тоо хэмжээг гарын авлагад заагдсан зааврын дагуу фото зургаар баримтжуулан холбогдох албан тушаалтнаар баталгаажуулж захиалагч талд албан бичгээр хүргүүлнэ. Зааврын дагуу фото зургаар баримтжуулаагүй, 7 хоног тутмын тайланд тусгагдаагүй ажилбар бүрийг гүйцэтгэлээс хасаж тооцно. Зурган баримтжуулалтад зориулалтын метр, рейк, гадас, самбар зэргийг ашиглана.</p> <p>8) Засвар шинэчлэлтийн ажлын хүрээнд тусгай зөвшөөрөл бүхий үйлдвэрт бэлтгэсэн түүхий эд, материал хэрэглэх бөгөөд захиалагч байгууллагаас зөвшөөрөл авсан үндсэн дээр гэрээ байгуулна.</p>
<p><b>6.Бусад</b></p>	<p>Авто замын засвар шинэчлэлтийн ажил дууссан өдрөөс хойш 21 хоногийн дотор гүйцэтгэлийн баримт бичгийг захиалагчид цаасаар болон цахим (НЗХГ-ын даргын 2022 оны А/40 дүгээр тушаалын хавсралтад заасан) хэлбэрээр хүлээлгэн өгнө.</p>

**Гэрээт ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай инженер техникийн ажилтан**

№	Албан тушаал	Ажилтны тоо	Боловсрол мэргэжлийн ур чадвар	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага
1	Ерөнхий инженер	1	Авто замын инженер	5 болон түүнээс дээш
2	Авто замын инженер	1	Авто замын инженер	3 болон түүнээс дээш

3	Материалын инженер	1	Авто замын инженер (материалын инженер чиглэлээр ажилласан туршлагатай)	2 болон түүнээс дээш
4	Геодезийн инженер	1	Геодезийн инженер эсвэл авто замын инженер	2 болон түүнээс дээш
5	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	1	(ХАБЭА сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх)	1 болон түүнээс дээш

**Гэрээт ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай машин механизм, тоног төхөөрөмжүүд**

№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Тоо ширхэг	Хүчин чадал	“Өөрийн эзэмшил” эсхүл “түрээс” аль нэгийг бичих
1	Усны машин	1	5 тн-с дээш	Өөрийн эзэмшил
2	Эксковатор	1	0.65 м3-с дээш	Өөрийн эзэмшил
3	Асфальтбетон дэвсэгч	1	7 м-с дээш	Өөрийн болон түрээс
4	Автогудронатор	1	3000 л-с дээш	Өөрийн болон түрээс
5	Ачааны автомашин	6	10 тн-с дээш	Өөрийн эзэмшил-3, түрээс-3
6	Хийн дугуйт индүү	1	8 тн-с дээш	Өөрийн болон түрээс
7	Гөлгөр булт индүү	1	2 тн-с дээш	Өөрийн эзэмшил
8	Гөлгөр булт индүү	1	6 тн-с дээш	Өөрийн болон түрээс
9	Бага оврын ачааны машин	2	1-5 тн	Өөрийн эзэмшил
10	Компрессор	1	110 м.х	Өөрийн
11	Нүүдлийн цахилгаан үүсгүүр	1	30 квт -аас багагүй	Өөрийн
12	Зөөврийн гагнуурын аппарат	1	500а	Өөрийн
13	Гар нягтруулагч	1	90кг, 120 кг	Өөрийн
14	Шөнийн цагт ажиллахад ашиглах талбайн гэрэлтүүлэг	2	ком	Өөрийн
15	Гэрэл ойлгогчтой зөөврийн түмбэ, замын хаалт, зөөврийн тэмдэг, тууз, угсардаг хашаа	Хангалттай хэмжээгээр		
16	Автомат нивелир /теодолит/	1	ком	Өөрийн
17	Асфальтбетон зүсэгч, чулуу зүсэгч хөрөө	1	<150мм	Өөрийн
18	Талбай дээрх ажлыг фото зургаар баталгаажуулхад шаардагдах багаж хэрэгсэл /Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлага 2017-д тусгагдсан/	1	ком	